

## **БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

### **Нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв**

#### **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвөөс 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрсэн түвшинг тогтоон, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

#### **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Эрүүл мэндийн байгууллагын 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажил үүргийн хуваарийн дагуу харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн тайлан, яамны газар, хэлтсүүдээс гаргасан холбогдох мэдээ, мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлт, Хэрэглэгчийн үнэлгээний тайлангуудтай харьцуулалт хийх, тодруулга авах зэрэг үндсэн аргуудыг ашиглан гүйцэтгэсэн болно. Мөн тайлангын чанар, мэдээллийн бодит байдал, тайлан ирүүлэх хугацааг баримталсан байдал зэргийг үнэлгээний дүнд харгалзсан болно.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
3. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үүнд:
  - Үйл ажиллагааны ил тод байдал;
  - Хүний нөөцийн ил тод байдал;
  - Шилэн дансны хөтлөлт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
5. Хэрэглэгчийн үнэлгээ

### Үнэлгээний нэгдсэн хүснэгт

Үзүүлэлт		Хувь	Оноо	
1	2	3	5	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	80,0	4,08	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	74,3		
	3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	82,6		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	4. Байгууллагын ил тод байдал	Үйл ажиллагааны ил тод байдал		74,4
		Хүний нөөцийн ил тод байдал		80,0
		Шилэн дансны хөтлөлт	95,0	
	5. Хэрэглэгчийн үнэлгээ	86,0		
Ерөнхий үнэлгээ:		81,6		

**Нэг.** Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

ЭМХТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.5 хүснэгтийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайлагнасан байна. Байгууллагын төлөвлөгөөнд 8 үндсэн зорилтын хүрээнд 50 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2021 онд 80,0%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 0,16 байна.

**Хоёр.** Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

ЭМХТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.6 хүснэгтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 74,3%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 0,11 байна.

**Гурав.** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт:

ЭМХТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.8 хүснэгтийн дагуу Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг тайлагнасан байна. Байгууллагын ирүүлсэн тайлан, Эрүүл мэндийн яамны холбогдох газар хэлтсийн мэдээ мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлтэд үндэслэн үнэлгээг гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт 82,6%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 0,24 байна.

**Дөрөв.** Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт:

ЭМХТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.7 хүснэгтийн дагуу байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийн тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу ирүүлсэн ба хэрэгжилт 83,1%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 0,12 байна.

**Тав.** Хэрэглэгчийн үнэлгээ:

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.2 дахь хэсэгт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийж ирүүлэх ба уг үнэлгээний дүнг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглахаар заасан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэглэгчийн үнэлгээний дүнгийн талаар эрүүл мэндийн

байгууллагын удирдлага, бодлого боловсруулагч нарыг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино. Үнэлгээгээр хэрэглэгчийн сэтгэл ханамж 86,0%-тай үнэлэгдсэн байна.

### **Дөрөв. Санал, зөвлөмж**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилт 81,6%-ийн гүйцэтгэлтэй буюу 4,08 оноотойгоор “В” үнэлэгдэв.

Анхаарах асуудлууд:

- Эрүүл мэндийн сайдын 2021 оныс А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.9-ын дагуу Эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг ирүүлж байх
- “Байгууллагын гүйцэтгэлийн тайлан”-г Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гаргаж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.8; Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 тушаалаар батлагдсан журмын 6.8 заалтуудад тусгагдсаны дагуу тайланг товч тодорхой, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж байх
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан журмын 7.2 дугаарт Эрүүл мэндийн хөгжлийн төв жил бүр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулах ба 5.19 дугаарт Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа Эрүүл мэндийн хөгжлийн төв зохион байгуулахаар заасан. Цаашид хэрэглэгчийн сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийж, байгууллагуудыг бүрэн хамруулж, ойлгомжтой, шаардлага хангахуйц тайланг дүгнэлт зөвлөмжийн хамт ирүүлж байх

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**